



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/84

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал,  
амралтын газрын үйл ажиллагаа  
эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй  
болгох тухай

Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

1150500281

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Тэрэлж сүйх ХХК-ийн “Тэрэлж” зочид буудлын 17/231, Ашид Орших ХХК-ийн “Грийт” зочид буудлын 17/049, Эс Би Эйч ХХК-ийн “Мандарин” зочид буудлын 17/302, Текотек трейд ХХК-ийн “Од сар” дэн буудлын 17/175, Хөх молор ХХК-ийн Молор дэн буудлын 17/243, Оршил гранд ХХК-ны Оршил ресорт амралтын газрын 17/216 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг тогтоол шийдвэр, тайлан, төлөвлөгөө хариуцсан мэргэжилтэн /Э.Мөнхзул/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 10  
сарын 29 өдрийн А/84 дүгээр  
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ 48936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.10.29

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хөх молор ХХК	2693267	Бирк -Birg	БГД-ийн 11-р хороо Энэбишийн өргөн чөлөө
2	Ашид орших ХХК	5237653	Грийт	БГД-ийн 2-р хороо Сөүлийн гудамж 45/5 тоот
3	Эс Би Эйч ХХК	5799236	Мандарин	БЗД-ийн 22-р хороо 15 хороолол Энхтайваны өргөн чөлөө 84 тоот
4	Атар шим трейд ХХК	2595435	Зочид буудал	БЗД-ийн 14-р хороо Нарны гудамж 65/2 тоот
5	Тэрэлж Сүйх ХХК	5403715	Тэрэлж	Налайх дүүргийн 6-р хороо Жо-Ван овооны адаг
6	Буяка ХХК	6346251	Лорд	БГД-ийн 16-р хороо Орхоны 1-41

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 10  
сарын 29 өдрийн А/84 дүгээр  
тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.10.29

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хөх молор ХХК	2693267	Молор	БЗД-ийн 16-р хороо 16 хороолол Дандарбаатарын гудамж 14б
2	Сарандулам ХХК	5659108	Дэлгэрэх	БЗД-ийн 5-р хороо ХД/39 тоот
3	Шүүдрийн дусал ХХК	2793202	Прий	БЗД-ийн 4-р хороо Б.Доржийн гудамж АОС тоот
4	Шүүрхээ ХХК	5388368	Агь	БГД-ийн 20-р хороо Энхтайваны өргөн чөлөө 298
5	Эймасс ХХК	6351301	Дэн буудал	СБД-ийн 14-р хороо Хандгайтын 33-338
6	Текотек трейд ХХК	5920167	Од сар	ЧД-ийн 14-р хороо Хайлаастын-24 58б

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 10  
сарын 29 өдрийн А/84 дүгээр  
тушаалын туравдугаар хавсралт

5284325 СБТ-8926 1115263502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.10.29

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Оршил гранд ХХК	5660955	Оршил ресорт	БЗД-ийн 20-р хороо Шар хоолойн аманд